

**Петро Матад Лимитед ("Петро Матад" эсвэл "Компани" гэх)
Үйл Ажиллагааны Талаархи Шинэчилсэн Мэдээлэл**

Петро Матад компани Давсан Толгой-4 цооногийг (цаашид "ДТ-4" гэх) галт уулын чулуулгаас бүрдсэн ул чулуулагт хүртэл буюу 2,038 метр өрөмдсөнийг мэдэгдэхэд таатай байна. Өрөмдлөгийн ажлын явцад анхны петрофизикийн шинжилгээгээр Доод Цагаанцав формацийн дээд хэсгээс авсан чөмгөн дээжээс наад зах нь 6 метрийн зузаантай тост үеийг агуулсан тосны ханалт бүхий үе байгааг тогтоолоо. Бид 2011 онд хийх ёстой цооногийн туршилтын ажлын хүрээнд энэхүү бүсийг судална. Мөн тэрчлэн ДТ-4 цооногийн илүү гүн хэсэгт нүүрсустөрөгчийн үе байгааг тогтоосон бөгөөд үүнийг петрофизикийн болон чөмөг дээжийн нарийвчилсан шинжилгээгээр судалж байна.

Компани ДТ-4 цооногийг Доод Цагаанцавын формацийн дээд хэсэг буюу 1,794 метрийн гүнд (каротажийн бичиглэл хийхэд тохирох гүнд) хүртэл өрөмдсөнийг өмнө нь мэдээлсэн билээ. Доод Зүүнбаянгийн давхаргын дээд хэсгээс хийн түвшин огцом нэмэгдэж, Доод Цагаанцавын формацийн агуулагч давхарга хүртэл үргэлжилсэн. Доод Цагаанцаваас авсан дээж нь нүүрсустөрөгчийн үнэртэй, газрын тосны ул мөртэй, флуоренсценц болон урсац бүхий сүвшил сайтай, "амьд" тосны илрэлтэй болохыг харуулсан.

Цооногийн 1,797.5 метрээс 1,831.3 метрийн хооронд гүнээс 4 ширхэг чөмгөн дээж авсан. Чөмгөн дээжийн дээд хэсгийн 8 метрт нүүрсустөрөгчийн үнэртэй, тосны ул мөртэй, флуоренсценц болон урсацын үзүүлэлттэй, муугаас сайн харагдацтай, нүх сүвшилтэй, нийтлэг бичил хагарал бүхий элсэн чулуу байгааг тогтоосон. 1,800 метрийн гүнээс авсан дээжинд газрын тос шингэсэн, ханалт өндөр байгааг харуулсан бөгөөд петрофизикийн эхний шинжилгээгээр энэхүү үед доод тал нь 6 метрийн зузаантай тост үе байгааг харуулж байна.

Чөмөг дээж авсан үлдсэн 26 метрийн хэсэгт нүүрсустөрөгчийн ханалтын хэмжээ аажмаар буурч, дээж авсан интервалын доод хэсэг рүүгээ нүүрсустөрөгчийн үнэр, тосны ул мөр, флуоренсценц болон урсац тасалдаж байсан.

Чөмгөн дээж авсан үеүүд буюу 1,840 метр, 1,870 метр, 1,905 метр, 1,982 метрийн гүнд өөр хоорондоо чанараараа ялгаатай газрын тосны 4 илрэл тогтоогдсон. 1,982 метрээс дээж авсаны дараа хийн түвшний үзүүлэлт нэмэгдсэн учир тав дахь чөмгөн дээжийг 1,983-1,992 метрээс авсан. Тус дээжнээс галт уулын гаралтай элсэн чулуу, шаваржин илэрсэн. Дээжний дунд хэсэгт 3 метрийн зузаантай, нүүрсустөрөгчийн үнэртэй, тосны ул мөртэй, флуоренсценц болон урсац бүхий элсэн чулуутай хэсэг байна.

Бид 2,032 метрийн гүн дэх галт уулын ул чулуулагт хүрэхийн өмнө нийт 238 метрийн зузаантай Доод Цагаанцавын хурдсыг дайрч өнгөрсөн. ДТ-4 цооногийн чөмгөн дээж болон петрофизикийн шинжилгээ хийсэн энэхүү хэсэгт дунджаар 15 хувийн нүх сүвшилтэй агуулагч давхаргын шинж чанартай ойролцоогоор 90 метрийн зузаан элсэн чулууны үеийг тогтоолоо.

ДТ-4 цооногийг Давсан Толгойн Хэтийн Төлөв Сайтай "Шороо" талбайн (хуучнаар "Баруун Давсан Толгой") томоохон хэсгийг хамарсан дөрвөн талаасаа хаагдсан гүдэн бүтцийг судлах зорилгоор өрөмдсөн. Давсан Толгойн "Шороо" талбай нь ДТ-1, ДТ-2 болон ДТ-3 цооногуудын өрөмдлөгөөр судлагдсан бүтцээс салангид бүтэц юм. Хэтийн Төлөв Сайтай "Шороо" талбай нь өрөмдлөгийн өмнөх тооцоогоор 69 хувийн амжилтын магадлалтай, эрсдэл тооцоогүй 41 сая

баррелийн таамаг нөөцтэй гэж гарсан. ДТ-4 цооногоос авсан чөмгөн дээжийн шинжилгээгээр мэдэгдэхүйц хэмжээний газрын тос болон агуулагч давхаргыг тогтоосон нь тус цооногоос дээш (ДТ-4) 235 метрийн өндөрт атирааны оройн хэсэг нь байрлах хэтийн төлөв сайтай “Шороо” талбайг үргэлжлүүлэн өрөмдөх шаардлагатайг харуулж байна.

Цооногоос авсан чөмгөн дээжийг нарийвчлан судлуулахаар АНУ руу илгээнэ. Компанийн хайгуулын багийнхан гадны зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтран каротажийн бичиглэлд нарийвчилсан дүн шинжилгээ хийнэ. ДТ-4 цооногийн каротажийн бичиглэл, яндан суулгалт, цементлэх ажлууд дуусч, Ди Кью И Интэрнешнл (DQE International) компанийн өрмийг дараагийн ДТ-5 цооногийн байрлал руу нүүлгэн шижлүүлж байна.

Петро Матадын Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас МакГэй хэлэхдээ “ДТ-4 цооногийн өрөмдлөгөөр өмнө нь өрөмдсөн Давсан Толгойн гүдэн бүтцээс салангид, өөр бүтцийг судалсан бөгөөд ДТ-4 цооногийн өрөмдлөгөөр илэрсэн мэдэгдэхүйц хэмжээний нүүрсустөрөгч нь тус цооногийн цаашдын хэтийн төлөв өндөр ач холбогдолтой болохыг харуулж байна. Энэхүү өрөмдлөг нь агуулагч давхарга болон түүний боломжит нөөцийн талаархи мэдлэгээ бататгах нэгэн алхам боллоо. ДТ-4 цооногийн урьдчилсан үр дүнгээс харахад тус цооног нь манай талбайтай хиллэдэг XIX талбайн Доод Цагаанцавын формациас олборлолт хийж байгаа цооногуудтай тун ижил болохыг харуулж байна” гэлээ.

Түүнчлэн “Бид 3 хэмжээст сейсмийн мэдээллийг дахин тайлал хийхээсээ өмнө ДТ-4 цооногийн байрлалыг тогтоож, өрөмдсөн. Тус цооногийн өрөмдлөгийг Давсан Толгойн хэмжээнд зөвхөн Доод Цагаанцавын формацийг судлах зорилготойгоор хийж гүйцэтгэсэн. Бид шинээр тайлал хийж тогтоосон Өвгөн Голын нүүрсустөрөгч хуримтлуулагч системийг оруулж, дахин боловсруулсан геологийн загварынхаа талаар 2011 оны 03 дугаар сарын 21-ний өдөр гаргасан мэдэгдэлдээ дурдсан билээ. Компани 2011 оны өрөмдлөгийн хөтөлбөрийн дагуу цаашид Өвгөн Голын нүүрсустөрөгч хуримтлуулагч систем болон Доод Цагаанцавын формацийг судална” гэж мэдэгдлээ.

Энэхүү шинэчилсэн мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүгэн хянасан болно. Доктор Күүгэн нь Хойд Америк, олон улсын хайгуулын болон ашиглалтын чиглэлээр 29 жил ажилласан туршлагатай, газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитед компанийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад XX талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км² талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитэд

Ерөнхий Гүйцэтгэх Захирал - Даглас Жэй МакГэй (Douglas J. McGay)

+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитэд

Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)

+44 (0)20 7601 6100